

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.06.02



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.86%
Монгол 27	2027.07.07	3.50%	6.84%
Хүннү	2028.01.19	8.65%	6.63%
Монгол 29	2029.06.05	7.875%	6.94%
Монгол 30	2030.02.25	6.625%	7.07%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.96%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.86%-7.07% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	9.76%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.71%
TDBM	2027.12.23	8.5%	10.21%
DBM	2026.03.07	11.00%	7.92%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 7.92%-12.71%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

GS BOND Supermarket

5 САРЫН ХАМГИЙН ЭРЭЛТТЭЙ БОНД

- Дэд бүтэц \$10%
- Банк санхүү 20%
- Уул уурхай \$11%
- Үл хөдлөх 18-20%

GS Бондын супермаркет нь хөрөнгө оруулагчдадаа бэлэн бондын тасагт байгаа 5 сарын хамгийн эрэлттэй бондуудаа санал болгож байна.

Дэд бүтэц : \$10%
 Банк санхүү : ₮20%
 Үл хөдлөх : ₮18%-20%
 Уул уурхай : \$11%

\$ АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД


АНУ-ын бондын ханш огцом савлаж, хөрөнгийн зах зээлд сөрөг дохио илгээв

Өнгөрсөн долоо хоногийн 20 жилийн хугацаатай төрийн бондын амжилтгүй дуудлага худалдаа хөрөнгийн зах зээл болон бондын үнэд сөргөөр нөлөөлсөн бол, энэ долоо хоногийн 7 жилийн хугацаатай бондын дуудлага худалдаа амжилттай болж, хөрөнгө оруулагчдын эрэлт өндөр байснаар дилерүүдэд ногдсон хэмжээ түүхэн доод түвшинд хүрлээ.

Үүний зэрэгцээ, өндөр өгөөжтэй бондууд төрийн бондуудаас давуу үзүүлэлттэй байж, хөрөнгийн зах зээл өссөн, тарифтай холбоотой эерэг мэдээллүүд болон хэрэглэгчийн итгэл сэргэсний үр дүнд ханш өсөв. Доллар үйлдвэрлэлийн салбарын уналтын улмаас 0.8%-иар унасан ч, АНУ-д ажиллах хүчний нээлттэй байрууд (JOLTS) хүлээлтээс давж өссөнөөр шөнөдөө бараг тэнцүү хэмжээгээр сэргэжээ.

Golomt_Capital published on TradingView.com, Jun 04, 2025 10:42 UTC-8

U.S. Dollar Index - 1W - TYX 099.408 1099.420 L96.563 C99.222 -0.221 (-0.22%) -0.027 (-0.03%)
Vol: The data vendor doesn't provide volume data for this symbol.



Хэдий долоо хоногийн төгсгөлд бондын зах зээл хэсэгчлэн сэргэж эхэлсэн ч энэ уналт нь зах зээлд тодорхой хэмжээнд итгэлгүй байдал үүсгэсэн.

Уг хямралыг Moody's агентлаг АНУ-ын зээлийн үнэлгээг бууруулсантай холбон тайлбарлаж байна. Moody's энэ алхмыг АНУ-ын төсвийн алдагдал нэмэгдэж, улсын өр өсөж буйд санаа зовнин хийсэн гэж тайлбарласан.

График 2. АНУ-ын 20 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж



ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын Засгийн газрын өрийн хэмжээ 34.6 их наядад хүрсэн

2025 оны I улирлын байдлаар Монгол Улсын Засгийн газрын өр 34.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3%-иар өссөн байна. Энэ өсөлтөд гадаад зээл, ялангуяа Азийн Хөгжлийн Банкнаас авсан их хэмжээний зээл, нүүрсний экспортын орлого багассантай холбоотой төсвийн нөхцөл хүндрэл зэрэг нь голлон нөлөөлжээ. Мөн 2024 оны I улирлаас хойш эдийн засгийн өсөлт удааширсан ч Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь улам өссөөр байгаа нь өрийн тогтвортой байдалд сөрөг дохио болж байна. Тухайлбал, 2025 оны эхний улиралд эдийн засаг 2.4%-иар өссөн ч, өрийн ДНБ-д эзлэх хувь 1.7 пунктээр нэмэгджээ.


Эх сурвалж: Bloomberg

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ТУСГАЙ САНАЛ 30%

8083-6622 | 8888-9183 | 8665-4422 | 8083-9944